

**“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2019 оны 06 сарын 04 өдөр

Арвайхээр сум

“Баянтээг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2019 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн 10 цаг 01 минутад Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, “Нутгийн удирдлагын ордон”-ны 203 тоот хурлын танхимд эхлэв.

Хурлын дарга А.Ишдорж

Хурлын дарга: “Баянтээг” Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа, Та бүхэнд хурлын ирцийг танилцуулъя, Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 дахь заалт, компанийн дүрмийн 6.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 93.54%-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг нээв.

Хурлаар хэлэлцсэн асуудлуудын жагсаалт:

1. Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх
2. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
3. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Саналын хуудсаар дараах шийдвэр гарав:

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн **93.54%** буюу **236,277** ширхэг хувьцаа эзэмшиж буй **2** хувьцаа эзэмшигчийн саналыг саналын хуудсаар авсан ба **2** буюу **100%** хүчинтэй байлаа.

Кумулятив аргаар өгөх саналын эрх 2,599,047 /хувьцааны тоо х 11/.

1. Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
2. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчид 0% зөвшөөрсөн, 100% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
3. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас орон нутгийн өмчийн төлөөллийн зүгээс ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн талаар зөвшилцөөгүй байгаа тул уг асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв. Тогтоолын төслийг хавсаргав.

Хурлыг 15 цаг 32 минутанд хаав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

/Б.Энхтуяа/

Хурлын дарга:

Тамга

/А.Ишдорж/

